



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/373

Булган сум

Сэлэнгэ үүлдрийн үхэр сүрэгт үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3, 18.3.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/205 дугаар “Үхэр сүргийн үүлдэрлэг байдлыг тодорхойлох ажлын төсвийн хуваарь батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал сумдын Сэлэнгэ үүлдрийн үхэр сүрэгт үзлэг ангилалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Ц.Бямбацогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн хяналтын Улсын байцаагч)

Ш.Болдбаатар (“Хужрын адаг” ХХК-ийн захирал)

М.Галдан (“Хөгнө мээж” ТББ-ын менежер)

Б.Гансүх (Тэшиг сумын Засаг дарга)

Ж.Ууганбаяр (Хутаг-Өндөр сумын Засаг дарга)

А.Ганбагана (Сэлэнгэ сумын Засаг дарга)

С.Ичинхорлоо (Хангал сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга)

2.Үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулах зардлыг хавсралтаар баталж, шаардагдах 3,236,949 (гурван сая хоёр зуун гучин зургаан мянга есөн зуун дөчин ес) төгрөгийг Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3.Сэлэнгэ үүлдрийн үхэр сүрэгт үзлэг ангилалт хийх ажилд хүн хүч, машин техник болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Үржлийн ажил үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулан, бүртгэл мэдээллийг “Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэх, мэргэжил арга зүй удирдлагаар ханган, хяналт тавьж, ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй шуурхай зохион байгуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 29-ны/ний өдрийн
А/373 дугаар захирамжийн хавсралт

ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙХ ХУВААРЬ, ШАТАХУУНЫ ТООЦОО

д/д	Сумын нэр	Маршрут	Малчин өрхийн тоо	Үхрийн тоо, толгой	Хугацаа /хоног/	Явах /км/	Шатахуун /литр/	Дүн
1	Хутаг-Өндөр	Булган-Хутаг-Өндөр сум				150	27	81,810
		Тээл багийн малчдаар	16	940	4	230	41	125,442
		Хонгор-Хантай			-	70	13	38,178
		Хонгор багийн малчдаар	23	1,295	4	150	27	81,810
		Хантай багийн малчдаар	29	1,885	7	270	49	147,258
		Баянгол багийн малчдаар	18	990	4	190	34	103,626
		Баянгол Хантай				50	9	27,270
		Хантай-Уньт				90	16	49,086
		Уньт багийн малчдаар	26	1,690	6	180	32	98,172
		Уньт- Булган			-	100	18	54,540
		Бүгд	112	6,800	25	1,480	266	807,192
2	Тэшиг	Төмрөнгийн эх, Ихрийн өвөр	20	650	2	110	20	59,994
		Өндрийн өвөр, Хужрын эх	15	550	2	100	18	54,540
		Застав	20	870	3	90	16	49,086
		Хужрын дунд үе, Хужрын төв	16	580	2	160	29	87,264
		4-р застав	21	910	4	140	25	76,356
		Бургаст, Өлзийтийн гарам	10	610	2	120	22	65,448
		Тусгалт, Доод арал	12	820	4	130	23	70,902
		Улаан эрэг, Төмрөнгийн адаг	14	554	2	105	19	57,267
		Бэрхийн ам	16	670	2	95	17	51,813
		Наран	11	290	1	90	16	49,086
		Харлан	10	296	1	80	14	43,632
		Бүгд	165	6,800	25	1,220	220	665,388
3	Сэлэнгэ	Булган-Сэлэнгэ сум		-	-	135	24	73,629
		Сэлэнгэ-Салуужин		-	-	120	22	65,448
		Салуужин-Сэлэнгэбүрэн малчдаар	15	975	3	70	13	38,178
		Сэлэнгэбүрэн-Атар				60	11	32,724
		Атрын малчдаар	21	1,365	5	150	27	81,810
		Атар-Сэлэнгэбүрэн				45	8	24,543
		Сэлэнгэ бүрэнгийн малчдаар	13	800	3	140	25	76,356
		Харцайн малчдаар	8	520	2	80	14	43,632
		Тариахтайн малчдаар	14	910	3	80	14	43,632
		Наран Баруун Баянголын малчдаар	12	780	3	100	18	54,540
		Цагаан тавилан Бухын адгийн малчдаар	11	715	2	60	11	32,724
		Хараагийн ар, Ингэтийн голын малчдаар	15	975	4	70	13	38,178

		Ихэт, Тарималын малчдаар	16	960	4	80	14	43,632
		Сэлэнгэ-Булган				135	24	73,629
		Бүгд	125	8,000	28	1,325	239	722,655
4	Хангал	Бөхөн, Мангирт	12	250	1	80	14	43,632
		Дэлэн Хуурай	10	460	2	75	14	40,905
		Цуврай, 4-р подъём, Дунд ам, Номт	22	670	2	90	16	49,086
		Зөөхий, Галтай, Майхан, Урт	50	920	3	110	20	59,994
		Чулуут, Тавхай	48	650	3	60	11	32,724
		Хандгайт	10	830	3	75	14	40,905
		Цулхар, Буурлын ар, Эргэлийн ар	45	500	2	85	15	46,359
		Сайр, Галтай, Модот, Сант. Тариат	60	300	1	125	23	68,175
		Сөрт, Баян нуга	35	650	2	60	11	32,724
		Хялганат /4-р баг	75	2,020	7	115	21	62,721
		Сумын төв	15	250	1	35	6	19,089
		Бүгд	382	7,500	25	910	164	496,314
		Хяналт тавих				1,000	180	545,400
		Нийт	784	29,100	103	4,935	888	3,236,949